

4.1 . Хог хаягдлын өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ

Улаанбаатар хотын хүн ам жил бүр тогтвортой өсөж байгаагаас үүдэн хүн амын төвлөрөл нийслэл хотод маш өндөр хэмжээнд байна. Дэлхийн банкнаас хийгдсэн Хатуу хог хаягдлын менежментийн олон улсын судалгаанд дурдсанаар нэг хүн өдөрт дунджаар 1.2 кг хог хаягдал үүсгэдэг байна. 2015 оны 1 сарын 1-ний байдлаар нийслэл хотод 1.3 сая хүн амьдарч байгаа ба зөвхөн өрхийн хэрэглээнээс гарч болох хог хаягдлын хэмжээг ерөнхийд нь тооцож үзвэл нийслэлийн нийт хүн амын өдөрт хаяж буй дундаж хогны хэмжээ 1500 тн орчим байна. JICA олон улсын байгууллагын судалгаанд өдөрт 1000-1500 тн хог хаягдал гардаг байна. (JICA, 2012) Зөвхөн айл, өрхийн хаягдлаас гадна бизнесийн байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрүүдийн хаягдал гэх мэт хог хаягдал гарч буй эх үүсвэр бүрээр хог хаягдлын бүтэц, хэмжээ онцлог, өөр өөр байна.

Одоогоор Монгол улсын хэмжээнд нийт 5 аймагт ажиллаж буй 200 гаруй цэгээр дамжуулан хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, тээвэрлэх, дахин боловсруулах, экспортлох зэрэг үйл ажиллагаа явуулснаар нийт хог хаягдлын 35 хувь гаруй хувийг дахин боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэн баялаг болгож байна

Улаанбаатар хотод 2015 онд 1 400 000 гаруй тонн хог хаягдал үүссэн /Зураг 10/ ба орон сууцны нэг иргэн өдөрт 650 гр, гэр хорооллын нэг иргэн өдөрт 800 гр хог хаядаг байна.

Зураг 10. Улаанбаатар хотын хог хаягдлын өсөлт. 2000-2015 он



Эх сурвалж: Судлаач

Монгол улсын хэмжээнд зөвшөөрөлтэй хогийн цэг 426, нийт 11.798 мянган га талбайг хамарч байна. Улаанбаатар хотын хогны хэмжээ жил бүр дунджаар 50 мянган тонноор нэмэгдэх хурдцыг хадгалж байна. Улаанбаатар хотод нэлээд хэдэн хогийн цэгүүд байдаг бөгөөд төвлөрсөн 3 хогийн цэгээс хамгийн том хогийн цэг нь Сонгинохайрхан дүүргийн 26-р хороонд оршдог Нарангийн энгэрийн хогийн цэг юм

Зураг 11. Улаанбаатар хотын хогийн цэг



Эх сурвалж: Судлаач

Эдгээр хогийн цэгүүдийн ажиллаж буй өнөөгийн механизмын тогтолцоо нь хогийн цэг дээр ил задгай хаядаг явдал юм. Энэ нь хогийн цэгээс эвгүй үнэр гарах

мөн түүнчлэн хогийн гэнэтийн шаталт үүсэх нөхцөл болдог. Овоолсон хогноос олон төрлийн хий гардгаас метан голлож гардаг. цугларсан хогийг технологийн дагуу дарж устгах ажил шаардлагын хэмжээнд бүрэн хийгдэж чадахгүй байна. Дээрх хог хаягдлыг хогийн төвлөрсөн гурван цэг болох

1. Нарангийн
2. Цагаан даваа
3. Морингийн даваанд ямар ч ангилан ялгалгүйгээр дүүргүүдийн тохижилт үйлчилгээний 6 компани зөөвөрлөн аваачиж хаядаг

Дүүргийн тохижилт үйлчилгээний компаниас бүх төрлийн хог хаягдлыг зайлуулах ерөнхий үнийг 1м^3 нь 350 төгрөг байхаар тооцдог боловч үйлдвэр, аж ахуйн газруудтай зохицсоны үндсэн дээр гэрээ байгуулж болдог

Хог хаягдлын ангилал: Хог хаягдлыг үүсч буй эх үүсвэрээс нь хамааран доорх төрлүүдэд хуваасан. Үүнд:

Зураг 12. Хог хаягдлын төрөл



Эх сурвалж: Судлаач

Хог хаягдлын урсгал

Хог хаягдлын урсгал нь эх үүсвэрээс гараад дахин боловсруулагдах, шатаах эсвэл ландфилл дээр булагдах хүртэл шат дамжлагыг харуулна. Хог хаягдлын ерөнхий урсгалыг дараах байдлаар тодорхойлов.

Зураг 13. Хог хаягдлын урсгал



Эх сурвалж: Судлаач

Хог хаягдлын ерөнхий урсгал эх үүсвэрээс, хогийн цэг хүртэл дээрх шат дамжлагатай боловч хаягдлын төрөл бүрээр урсгал нь ялгаатай байдаг.

Хаягдлын зах зээлийн хураангуй

Улаанбаатар хотын хог хаягдлыг дахин боловсруулахад түүхий эдийн нөөц хангалттай эсэхийг үнэлж, хог хаягдлын ангилал тус бүрээр бодит (хогийн цэг дээр бүртгэгдсэн хэмжээ) болон боломжит хог хаягдлын хэмжээг (хог хаягдал үүсгэгч хүчин зүйлийн потенциалын дагуу тооцоолсон) гаргаж, харьцуулж тооцоолов.

Хог хаягдлын тооцооллын аргачлал:

- а) Улаанбаатар хотын 3 том төвлөрсөн хогийн цэгийн хогны хэмжээг хоёрдогч түүхий эдийн цэгүүд дээрх хэмжээн дээр нэмж бодитой хаягдаж буй хогны хэмжээ тодорхойлсон:

Хогийн цэгүүдийн хэмжээ + Түүхий эдийн цэгүүдийн хэмжээ = Бодит хогийн хэмжээ.

Мөн түүнчлэн хогийн цэгүүд дээрх судалгаанаас дахин боловсруулах үйлдвэрлэлд ашиглаж болох дараах 10 нэр төрлийн хогны ангиллын дагуу судалсан.

- 1) Баттерей, аккумулятор

- 2) Тээврийн хэрэгслийн дугуй
- 3) Мал амьтны хаягдал (яс)
- 4) Электрон хэрэгслийн хаягдал
- 5) Лонх, шилний хаягдал
- 6) Хуванцар хаягдал
- 7) Төмөрлөгийн хаягдал (хар төмөр, зэс, гууль, хөнгөн цагаан, ган гэх мэт)
- 8) Барилгын хог хаягдал
- 9) Цаас, картоны хаягдал
- 10) Моторын тосны хаягдал

11) Нэг жилд үүсч буй хаягдлын хэмжээ-Улаанбаатар хот

Нэг жилд үүсч буй хаягдлын хэмжээ			
	Хаягдлын төрөл	Хэмжээ, тн/жил	Эзлэх хувь
5	Хуванцар pet	7,929.3	0.6%
6	Хуванцар бусад	7,338.1	0.5%

i. Хуванцар хаягдлын зах зээл

Танилцуулга: Хуванцар материалын хаягдал

Монгол улс хуванцар материал, хэрэглээний зүйлсийнхээ дийлэнх хэсгийг боловсруулсан болон хагас боловсруулсан бэлдэц байдлаар худалдан авч ашигладаг. Дотоодын үйлдвэрлэлийн салбарууд ялангуяа ундаа, жүүсний үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж байгаатай холбоотойгоор анхдагч хэлбэрт байгаа стиролын (тараг сүүний савлагаа, уян хуванцар эдлэлүүд тухайлбал CD гэх мэт) болон поликарбонат (бүх төрлийн тунгалаг, хагас тунгалаг шингэн зүйлсийн сав хийхэд ашиглагддаг) бэлдцүүдийн хэрэглээ ихээхэн нэмэгдэж байна. Сүүлийн 5 жилд эдгээр материалуудын импорт 10,223 тонноор нэмэгджээ.

Ундаа, жүүсний хуванцар савны бэлдэц, хаягдлын дараах орох хэрэглээний цар хүрээ өндөр хаягдал үүсгэгч бол гялгар уут юм. Монгол улс 2014 оны байдлаар 60 сая ширхэг гялгар уут импортоор авсан бөгөөд үүнийг стандарт жингээр тооцоолж

үзвэл 2014 оны хувьд 300 тонн хаягдал үүсгэхээр байна. Гэхдээ уутны хаягдлын хэмжээг тооцоолохдоо импортын бэлдэц ашиглан дотооддоо үйлдвэрлэж байгаа гялгар уут, хоолны пакет сав зэргийг хамруулж тооцоогүй болно.

Хэрэглээний цар хүрээгээрээ гялгар уутны дараах ордог хаягдал бол ургамлын тосны сав бөгөөд 2014 онд Монгол улс 22 сая литр ургамлын тос импортоор авсан.

Дахин боловсруулсан бүтээгдэхүүний хэрэглээ: Хуванцар материалын хаягдал
Хуванцар сав, эдлэлийг төрлөөс нь хамааран ялгаатай арга технологиор боловсруулж ялгаатай дараах бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх боломжтой.

Эх сурвалж.:Хог Хаягдлыг Дахиан Боловсруулах Үндэсний холбоо

Хог хаягдлын хэмжээ болон дахин боловсруулж буй байдал :
Улаанбаатар хотоос гарч буй хог хаягдлын хэмжээ -1,433,431 тн/жил бөгөөд одоогийн байдлаар

1. Дахин боловсруулж буй хувь-24% болно.
2. Дахин боловсруулж буй хог хаягдлын хэмжээ - 344.403 тн/жил /Хүснэгт-1 с харна уу/
3. Эдийн засгийн эргэлтийн хэмжээ нийт: 70,176,347,000 төг/жил
4. Дахин боловсруулах боломжиг хувь -85 %
5. Дахин боловсруулах боломжтой нийн хог хаягдал хэмжээ- 1.242.642 тн/жил /Эко-Парк төслийн УТЭЗҮ-ийн тооцоолоос авав.

Д/д	Хаягдлын төрөл	Хэмжээ, тн/жил	Дахин ашиглах, дахин боловсруулж буй хэмжээ тн/жил	Үүсч буй хог хаягдлыг дахин ашиглаж , дахин боловсруулж буй хувь тус бүрээр /Хог хаягдлын төрөл тус бүрээр харьцуулсан/ %	Дахин ашиглах, дахин боловсруулж буй хувь, /нийт хог хаягдалтай харьцуулсан %/
1	Барилгын болон шилний хаягдал	319945.5	36176	11	2.5
2	Бүх төрлийн хуванцар	69044.8	42292	61	2.9
3	Хоол хүнсний хаягдал	304028.3	60806	20	4.2
4	Хаягдал төмөр, өнгөт металл	134145.3	119388	89	8.3
5	Цаас болон картоны хаягдал	104650.7	14527	13	1.0
6	Малын гаралтай хог хаягдал	7248.2	3561	49	0.2
7	Аюултай хог хаягдал/дугуй, аккумулятор, моторын ажилласан тос, электрон хог хаягдал/	8647.9	1749.22	20	0.1
8	Бусад /булагдсан хог хаягдлын хэмжээ/	485720.5	65903.78	13	4.5
	Нийт	1,433,431	344.403		24

Хаягдал хуванцар материалыг дахин ашиглах боломж

Хуванцарын төрөл	Хэрэглээ	Хаягдлаас үйлдвэрлэж болох бүтээгдэхүүн
PET or PETE (Polyethylene Terephthalate Ethylene)	Ундаа ус, шар айрагны сав, ургамлын тосны сав, самрын тосны сав	Автомашинны эд ангиуд, ачааны өлгүүр болон тавиур, эрчим хүчний тохируулгын хайрцаг, машинны ард болон урд гүүпер, салхивч, цүнх болон шинэ сав
HDPE (High Density Polyethylene)	Сүү, жүүсний лонх, цайруулах, угаалгын нунтгийн сав, шампуний сав, моторын тосны сав, цөцгийн тос болон тарагны сав,	Угаалгын бодисын сав, тосны сав, хуванцар үзэг бал, шалны хавтанцар, ус дамжуулах хоолой, хашаа, нохой зэрэг амьтны байр, байшин, шуудангийн хайрцаг, аяллын ширээ, сандал, хүүхдийн тоглоом
PVC (Polyvinyl Chloride)	Цонх цэвэрлэгч шингэний сав, савангийн сав, тосны сав, нэг удаагийн болон байнгын хоолны савнууд, эмнэлгийн тоног төхөөрөмж, цонх, суваг хоолой,	Шал, кабелийн утасны гадар, замын хурд сааруулагч, машинны шаврын хаалт, хуванцар брожур
LDPE (Low Density Polyethylene)	Гялгар уут, хүнсний сагс, нэг удаагийн аяга, нэг удаагийн хоолны сав, тавилга, хувцас, хивс	Хулдаас, хуванцар хогийн сав, задгай хогийн сав, шуудангийн хавтас, хана, шалны хавтанцар.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо